



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/239

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах нь” сэдэвт сургалтыг зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамж, хөтөлбөрийг нэгдүгээр, шаардагдах зардлын хэмжээг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалтыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтад заасны дагуу төсвийн Хичээл үйлдвэрлэлийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

4. Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг танилцуулахыг Статсистик, мэдээллийн технологийн алба /М.Цэнгүүн/-д үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын алба /Ч.Баттулга/-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн А/239 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ”  
СЭДЭВТ ЦУВРАЛ СУРГАЛТЫН УДИРДАМЖ, ХӨТӨЛБӨР**

**Сургалтын хэрэгцээ:** Эрүүл мэндийн салбарт шинэ техник, технологт, цахим анагаах ухааны салбар хөгжиж байгаа, шинээр програм хангамж нэвтэрч байгаатай холбогдуулан эрүүл мэндийн байгууллагуудад ажиллаж байгаа мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, ажлын байрны сургалтыг шат дараатайгаар зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгараад байна. Иймд мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийн сургалтыг шат дараатайгаар зохион байгуулах нь алдаа дутагдал гаргахаас урьдчилан сэргийлэх, шинэ техник технологи, програм хангамж дээр ажилладаг болох үр дүнтэй арга зам билээ.

**Сургалтад хамрагдах бүлэг:** Хөдөө орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй мэдээллийн технологийн ажилтнууд.

**Сургалт явуулах баг:**

№	Нэрс	Мэргэшил, боловсролын зэрэг	Мэргэжлээрээ ажилласан жил
1	Эрдэнэбатын Амарсанаа	Мэдээлэл технологийн инженер, сургагч багш	9

**Сургалтын зохион байгуулалт:**

- Цахим хэлбэрээр

**Сургалтын үргэлжлэх хугацаа:** 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр


**Сэдэвчилсэн хөтөлбөр:**

Он, сар	Цаг	Хичээлийн сэдэв	Багшийн нэр	Сургалтын	Хугацаа
---------	-----	-----------------	-------------	-----------	---------

өдөр				хэлбэр	(мин)
2017.12.126	10:00-12:00	Системийн шинжилгээ	Э.Амарсанаа	Цахим	90 мин
	12:30-14:30	UML 2.0 ойлголт ба хэрэглээ	Э.Амарсанаа	Цахим	90 мин
	15:30-17:30	Өгөгдлийн сангийн зохион байгуулалт	Э.Амарсанаа	Цахим	90 мин

19 Ерөнхий захирлын 2017 оны 12 дугаар сарын  
... өдрийн А дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

239



**“МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ НЬ”  
СУРГАЛТЫН ТӨСӨВ**

Зардлын нэр	Нэгж тооцоо	Төсөвлөсөн /төг/
Үйл ажиллагааны зардал /багшийн хөлс/	(50*46000)	2.300.000
<b>Нийт дүн</b>		<b>2.300.000</b>

Хянасан:

Ахлах ня-бо

Боловсруулсан

Д.Гантуяа

М.Цэнгүүн